



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн
2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн
аудитын тайлан

Аудитын код: ДГА-2025/123/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 он	Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захирал, Тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 7052-2734 Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 7052-3020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Ахлах аудитор/Аудитор: З.Ундармаа Утас: 8901-1289 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Ахлах аудитор/Аудитор: Т.Золбоо Утас: 9111-1254 Цахим хаяг: babi.tami.audit@gmail.com Аудитор: Б.Батчимэг
-----------------------------------------------------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

1. Хараат бус аудиторын дүгнэлт



САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН 2 ДУГААР СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Ч.АМАРЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тус сургууль нь өмчийн өөрчлөлтийн тайланд Засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдэл 1,834.5 сая төгрөгийг хуримтлагдсан үр дүн данс руу бүртгэж, төрийн өмчийн дүнг санхүүгийн тайланд илэрхийлээгүй зөрчлийг залруулан бүртгүүлсэн.

Аудитын гол асуудал

Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,371.6 сая төгрөгийг 2022 онд хуримтлагдсан үр дүн данс руу бүртгэж, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн байдлын тайланд дүнг тусгаагүй байна.

Бусад асуудлын хэсэг

Сайншанд сумын Ерөнхий боловсролын 2 дугаар сургуулийн 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 47 арга хэмжээ төлөвлөж, хэрэгжилтийг 77.1 хувиар үнэлсэн байна.

447502011

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	417,212,638.81	620,409,989.46
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	229,217,599.93	409,909,387.18
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	229,217,599.93	409,909,387.18
3121	Төгрөг	229,217,599.93	409,909,387.18
31211	Төрийн сангийн харилцах	194,028,108.99	387,419,896.24
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	35,189,490.94	22,489,490.94
33	АВЛАГА	829,947.00	662,914.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	829,947.00	662,914.00
35	БАРАА МАТЕРИАЛ	187,165,091.88	209,837,688.28
351	Түүхий эд материал	33,595,874.10	33,123,648.10
35110	Тусгай зориулалттай материал	32,784,291.10	32,784,291.10
35130	Эм боох материал	811,583.00	339,357.00
354	Хангамжийн материал	153,569,217.78	176,714,040.18
35410	Бичиг хэргийн материал	835,280.00	1,137,350.00
35420	Аж ахуйн материал	11,078,858.76	33,442,511.16
35470	Бусад хангамжийн материал	141,655,079.02	142,134,179.02
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,422,379,238.41	7,294,540,471.89
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,422,379,238.41	7,294,540,471.89
392	Биет хөрөнгө	7,031,727,383.97	6,904,140,471.89
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,657,143,206.37	6,657,143,206.37
39202	Хуримтлагдсан элэгдэл	-323,703,537.00	-461,090,231.82
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	721,979,097.98	842,066,411.98
39206	Хуримтлагдсан элэгдэл	-282,377,510.87	-414,034,255.81
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	233,662,555.01	276,851,495.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-110,221,342.26	-135,657,737.61
39214	Бусад үндсэн хөрөнгө	23,955,631.47	27,455,631.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	-6,031,803.84	-8,386,034.41
39217	Ном	117,321,087.11	119,791,986.71
393	Биет бус хөрөнгө	390,651,854.44	390,400,000.00
39301	Програм хангамж	1,727,000.00	1,727,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,475,145.56	-1,727,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	390,400,000.00	390,400,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,839,591,877.22	7,914,950,461.35
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	24,875,662.60	28,590,886.87
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	24,875,662.60	28,590,886.87
413	Өглөг	24,875,662.60	28,590,886.87
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	22,709,212.73	288,425.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	25,500.00	-
4136	Бусад өглөг	2,140,949.87	28,302,461.87
41361	Байгууллагад төлөх өглөг	701,900.00	25,991,512.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,439,049.87	2,310,949.87
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,814,716,214.62	7,886,359,574.48
51	Засгийн газрын хувь оролцоо	7,814,716,214.62	7,886,359,574.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	-	1,834,541,954.01
51101	Өмч: - төрийн		1,834,541,954.01
512	Хуримтлагдсан үр дүн	7,814,716,214.62	6,051,817,620.47
51210	Өмнөх үеийн үр дүн	7,814,716,214.62	5,997,662,682.67
51220	Тайлант үеийн үр дүн	-	54,154,937.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,839,591,877.22	7,914,950,461.35

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	7,540,672,181.31	4,030,771,102.79
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,366,745,183.78	97,122,607.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,366,745,183.78	97,122,607.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,686,987.00	25,114,582.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,501,339.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,185,648.00	25,114,582.00
120017	Үнэ төлбөргүй хүлээ авсан орлого-Үндсэн хөрөнгө	4,337,605,194.90	64,839,029.60
120018	Үнэ төлбөргүй хүлээ авсан орлого-Бараа материал	8,453,001.88	7,168,995.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,173,926,997.53	3,933,648,495.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,904,854,200.00	3,477,482,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,904,854,200.00	3,477,482,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	269,072,797.53	456,166,495.79
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	269,072,797.53	456,166,495.79
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,136,170,380.05	3,976,616,164.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,136,170,380.05	3,976,616,164.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,963,458,080.05	3,788,535,664.99
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,109,993,580.20	2,535,864,988.08
210101	Үндсэн цалин	1,406,728,951.55	1,634,364,957.76
210102	Нэмэгдэл	653,375,214.30	830,152,800.32
210104	Урамшуулал	49,889,414.35	71,347,230.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	273,668,068.76	313,993,729.03
210201	Тэтгэврийн даатгал	188,575,822.85	216,399,716.39
210202	Тэтгэмжийн даатгал	21,605,359.63	25,672,079.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,284,027.71	13,023,774.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,187,941.32	12,004,389.95
210205	Эрүүл мэндийн даатгал	42,014,917.25	46,893,769.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,072,797.53	448,552,506.79
210301	Гэрэл, цахилгаан	14,335,757.53	24,993,187.52
210302	Түлш, халаалт	229,080,640.00	392,505,438.00
210303	Цэвэр, бохир ус	17,656,400.00	31,053,881.27
2104	Хангамж, бараа материалын зардал	37,441,480.00	29,585,966.18
210401	Бичиг хэрэг	23,349,148.00	5,381,230.00
210402	Тээвэр, шатахуун	80,000.00	-
210404	Ном, хэвлэл	48,000.00	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,055,592.00	24,204,736.18
210408	Бараа материал акалсны зардал	9,908,740.00	-
2105	Нормативт зардал	444,502.00	1,342,916.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	438,502.00	1,342,916.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	6,000.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,467,981.19	8,223,491.82
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	110,000.00
210604	Урсгал засвар	6,467,981.19	8,113,491.82
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	30,266,418.55	62,878,693.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,034,500.00	2,055,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	20,231,918.55	60,823,393.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	244,103,251.82	388,093,373.40
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	42,219,472.33	60,869,553.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	11,352,950.00	30,137,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	190,530,829.49	297,085,920.12
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	172,712,300.00	188,080,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	172,712,300.00	188,080,500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	166,747,500.00	175,780,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	5,964,800.00	12,300,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>4,404,501,801.26</u>	<u>54,154,937.80</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>4,404,501,801.26</u>	<u>54,154,937.80</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>3,194,613,984.53</u>	<u>3,968,763,077.79</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	20,686,987.00	35,114,582.00
120	Нийтлэг татварын бус орлого	20,686,987.00	35,114,582.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	20,686,987.00	25,114,582.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,501,339.00	-
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,185,648.00	25,114,582.00
120009	Бусад орлого	-	10,000,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,173,926,997.53	3,933,648,495.79
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,904,854,200.00	3,477,482,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,904,854,200.00	3,477,482,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	269,072,797.53	456,166,495.79
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	269,072,797.53	456,166,495.79
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	<u>2,926,201,223.54</u>	<u>3,713,040,578.54</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	<u>2,926,201,223.54</u>	<u>3,713,040,578.54</u>
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	<u>2,753,424,223.54</u>	<u>3,523,571,178.54</u>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,102,822,111.37	2,549,884,084.84
210101	Үндсэн цалин	1,399,557,482.72	1,649,885,112.42
210102	Нэмэгдэл	653,375,214.30	828,843,906.68
210104	Урамшуулал	49,889,414.35	71,155,065.74
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	268,735,703.09	315,487,729.94
210201	Тэтгэврийн даатгал	183,643,457.18	217,399,316.39
210202	Тэтгэмжийн даатгал	21,605,359.63	25,789,679.06
210203	ҮОМШӨ-ний даатгал	17,284,027.71	13,082,574.26
210204	Ажилгүйдлийн даатгал	4,187,941.32	12,087,190.86
210205	Эрүүл мэндийн даатгал	42,014,917.25	47,128,969.37
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	261,072,797.53	448,552,506.79
210301	Гэрэл, цахилгаан	14,335,757.53	24,993,187.52
210302	Түлш, халаалт	229,080,640.00	392,505,438.00
210303	Цэвэр, бохир ус	17,656,400.00	31,053,881.27
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,000,000.00	7,290,550.00
210604	Урсгал засвар	8,000,000.00	7,290,550.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,567,918.55	69,989,293.69
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,034,500.00	9,165,900.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	18,533,418.55	60,823,393.69
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	84,225,693.00	132,367,013.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,980,342.00	102,229,113.28
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,245,351.00	30,137,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	<u>172,777,000.00</u>	<u>189,469,400.00</u>
2132	Бусад урсгал шилжүүлэг	172,777,000.00	189,469,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	166,722,000.00	176,169,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,055,000.00	13,300,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>268,412,760.99</u>	<u>255,722,499.25</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	101,692,000.00	75,030,712.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	101,692,000.00	75,030,712.00
2200	Дотоод эх үүсвэрээр	101,692,000.00	75,030,712.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	101,692,000.00	75,030,712.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-101,692,000.00	-75,030,712.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	166,720,760.99	180,691,787.25
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	62,496,838.94	229,217,599.93
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	229,217,599.93	409,909,387.18

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	7,814,716,214.62	7,814,716,214.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	7,814,716,214.62	7,814,716,214.62
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	-	-
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	7,814,716,214.62	7,814,716,214.62
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	7,814,716,214.62	7,814,716,214.62
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-1,817,053,531.95	-1,817,053,531.95
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	5,997,662,682.67	5,997,662,682.67
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	1,834,541,954.01	-	-	1,834,541,954.01
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	54,154,937.80	54,154,937.80
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,834,541,954.01	-	6,051,817,620.47	7,886,359,574.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,149,019,300.00	3,765,371,290.54	-383,648,009.46	90.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,149,019,300.00	3,765,371,290.54	-383,648,009.46	90.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,953,652,000.00	3,588,201,890.54	-365,450,109.46	90.76
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,810,902,200.00	2,549,884,084.84	-261,018,115.16	90.71
210101	Үндсэн цалин	1,891,160,100.00	1,649,885,112.42	-241,274,987.58	87.24
210102	Нэмэгдэл	867,015,600.00	828,843,906.68	-38,171,693.32	95.6
210104	Урамшуулал	52,726,500.00	71,155,065.74	18,428,565.74	134.95
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	351,362,700.00	315,487,729.94	-35,874,970.06	89.79
210201	Тэтгэврийн даатгал	238,926,600.00	217,399,316.39	-21,527,283.61	90.99
210202	Тэтгэмжийн даатгал	28,109,000.00	25,789,679.06	-2,319,320.94	91.75
210203	ҮОМШӨ-ний даатгал	14,054,500.00	13,082,574.26	-971,925.74	93.08
210204	Ажилгүйдлийн даатгал	14,054,500.00	12,087,190.86	-1,967,309.14	86

210205	Эрүүл мэндийн даатгал	56,218,100.00	47,128,969.37	-9,089,130.63	83.83
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	453,130,700.00	448,552,506.79	-4,578,193.21	98.99
210301	Гэрэл, цахилгаан	24,850,000.00	24,993,187.52	143,187.52	100.58
210302	Түлш, халаалт	395,637,200.00	392,505,438.00	-3,131,762.00	99.21
210303	Цэвэр, бохир ус	32,643,500.00	31,053,881.27	-1,589,618.73	95.13
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	7,300,000.00	7,290,550.00	-9,450.00	99.87
210604	Урсгал засвар	7,300,000.00	7,290,550.00	-9,450.00	99.87
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	94,440,900.00	79,989,293.69	-14,451,606.31	84.7
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	9,165,900.00	9,165,900.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,964,200.00	-	-9,964,200.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	84,476,700.00	70,823,393.69	-13,653,306.31	83.84
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	236,515,500.00	186,997,725.28	-49,517,774.72	79.06
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	204,940,500.00	156,859,825.28	-48,080,674.72	76.54
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	31,575,000.00	30,137,900.00	-1,437,100.00	95.45
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	195,367,300.00	177,169,400.00	-18,197,900.00	90.69
2132	Бусад урсгал шилжүүлэг	195,367,300.00	177,169,400.00	-18,197,900.00	90.69
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	194,367,300.00	176,169,400.00	-18,197,900.00	90.64
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00	-	100
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,149,019,300.00	3,958,763,077.79	-190,256,222.21	95.41
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	3,668,252,600.00	3,477,482,000.00	-190,770,600.00	94.8
131001	Улсын төсвөөс санхүүжих	3,668,252,600.00	3,477,482,000.00	-190,770,600.00	94.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	460,430,700.00	456,166,495.79	-4,264,204.21	99.07
132001	Орон нутгийн төсвөөс	460,430,700.00	456,166,495.79	-4,264,204.21	99.07
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,336,000.00	25,114,582.00	4,778,582.00	123.5
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,455,700.00	-	-7,455,700.00	0
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	12,880,300.00	25,114,582.00	12,234,282.00	194.98
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		194,028,108.99	194,028,108.99	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		387,419,896.24	387,419,896.24	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ			-	
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	125	125	-	100
620001	Удирдах ажилтан	1	1	-	100
620002	Гүйцэтгэх ажилтан	86	86	-	100
620003	Үйлчлэх ажилтан	38	38	-	100

2.6 Аудит хийсэн ахмадын сангийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	22,700,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,400,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,400,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	12,300,000.00

2132	Бусад урсгал шилжүүлэг	12,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	12,300,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	10,000,000.00
12	Татварын бус орлого	10,000,000.00
120009	Бусад орлого	10,000,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	35,189,490.94
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	22,489,490.94

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,876.2 сая төгрөгийн 10 алдаа зөрчил илэрснээс, аудитын явцад 1,844.0 сая төгрөгийн 3 алдааг залруулж, залруулагдаагүй 32.2 сая төгрөгийн 7 зөрчилд 3 албан шаардлага, 4 зөвлөмжийг хүргүүлэв.

3.1. Аудитын явцад залруулсан алдаа:

1. Тайлант онд худалдан авсан 7,110.6 мянга, БШУЕГ-аас үнэ төлбөргүй хүлээн авсан 2,311.6 мянган төгрөгийн сурах бичгийг шууд зардалд бүртгэсэн байна.
2. Тус сургууль нь өмчийн өөрчлөлтийн тайланд засгийн газрын оруулсан капитал дансны үлдэгдлийг хуримтлагдсан үр дүн данс руу бүртгэж, төрийн өмчийн дүн 1,834.5 сая төгрөгийг санхүүгийн тайланд илэрхийлээгүй байна.
3. Үйлдвэрчний эвлэлийн байгууллагад төлөх 0.08 сая төгрөгийн өглөгийг дутуу бүртгэсэн.

3.2. Төлбөрийн акт:

Аудитаар тогтоосон төлбөрийн акт байхгүй болно.

3.3. Албан шаардлага:

1. Тайлант онд нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардлаас 1,000,000 төгрөгийн урсгал засварын материал худалдан авч, зориулалт бусаар зарцуулсан байна.
2. Тайлант онд эд хариуцагч солигдсон боловч эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, үлдэгдлийг баталгаажуулаагүй байна. Мөн жилийн эцсийн тооллогыг чанаргүй гүйцэтгэж, тооцоо бодоогүй байна.
3. Тайлант оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд батлагдсан хичээл үйлдвэрлэлийн зардлын худалдан авах ажиллагааг цахим системээр зарлаагүй, хуулийг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

3.4. Зөвлөмж:

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгөтэй холбоотой:

Илрүүлэлт: Үлдэгдэл өртөггүй 141 ширхэг 230,425.2 мянган төгрөгийн хөрөнгийг цаашид ашиглах боломжтой эсэхийг судалж, шийдвэрлүүлээгүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6-т “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолын 7.1-т “төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын

шимтгэлээр анхны үнийг нөхсөн, ...саналыг бэлтгэн ТӨБЗГ-т ирүүлж шийдвэрлүүлнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын дансанд бүртгэлтэй үлдэгдэл өртөггүй хөрөнгийг цаашид ашиглах боломжтой эсэхийг судалж, ашиглах боломжгүй хөрөнгийг актлах саналыг, харин ашиглах боломжтой хөрөнгийн дансны үнэ, ашиглах жилийг шинэчлэн тогтоох саналыг холбогдох байгууллагад хүргүүлж, шийдвэрлүүлэх

2. Өглөг, авлагатай холбоотой:

Илрүүлэлт: Тус байгууллага нь 662.9 мянган төгрөгийн авлага, 1,439.0 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй байна.

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-т *“төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”*, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар 20.2.5-т *“дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”*, 20.2.6-т *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулах, цаашид барагдуулах арга хэмжээ авч ажиллах

3. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой:

Илрүүлэлт: Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү 1,371.6 сая төгрөгийг 2022 онд хуримтлагдсан үр дүн дансанд бүртгэж, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй тайлан, санхүүгийн байдлын тайланд дүнг тусгаагүй байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д *“бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ”*, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д *“Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу үнэлж бүртгэнэ”* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлангийн *“иж бүрэн байх”* гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хөрөнгө тус бүрд тусгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх

4. Дотоод хяналт, хариуцлагатай холбоотой:

Илрүүлэлт: Худалдан авах ажиллагааны 208.9 сая төгрөгийн 2 тендер шалгаруулалтын ерөнхий мэдээллийг байршуулаагүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т *“мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”*, 4.1.3-т *“тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”*, 6 дугаар зүйлийн 6.3.6-т *“хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын ерөнхий*

мэдээлэл”, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.10-т “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны цахим системд байршуулаагүй мэдээллийг нөхөн байршуулж, цаашид хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах

Дээрх 4 зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад **2025 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор** ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өглөг бүртгээгүй	1	0.8	1	0.8	-	-	1	0.8	-	-	-	-
Шууд зардалд бүртгэсэн	1	9,422.2	-	-	1	9,422.2	1	9,422.2	-	-	-	-
Эздийн өмчийн дүнг тусгаагүй	1	1,834,541.9	-	-	1	1,834,541.9	1	1,834,541.9	-	-	-	-
Дүн	3	1,843,964.9	1	0.8	2	1,843,964.1	3	1,843,964.9	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/							
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үлдэгдэл өртөггүй хөрөнгийг шийдвэрлүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-	-	-
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүүг хуримтлагдсан үр дүн дансанд бүртгэсэн	1	-	-	-	-	-	1	-	-	-
Авлага, өглөгийг тооцоо нийлж баталгаажуулаагүй	1	-	-	-	-	-	1	-	-	-

Зориулалт бус зарцуулалт	1	1,000.0	-	-	1	1,000.0	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн тооллого хийгдээгүй	1	-	-	-	1	-	-	-	-	-
Дүн	5	1,000.0	-	-	2	1,000.0	3	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
ТБОНӨАБАҮХА тухай хуулийн хэрэгжилт хангалтгүй	1	31,278.6	-	-	1	31,278.6	-	-
Дүн	1	31,278.6	-	-	1	31,278.6	-	-
Нийт дүн	2	31,278.6	-	-	1	31,278.6	1	-